

**АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ АСУУДЛЫН ДЭД ХОРООНЫ
БҮРЭЛДЭХҮҮНД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ АСУУДЛААР БАЙГАЛЬ
ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН ХОРООНООС
ГАРСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 01 дүгээр
сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын
гишүүн Ц.Оюунгэрэл**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт заасныг баримтлан Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2015 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулж байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.5-д Байнгын, дэд, түр хорооны бүрэлдэхүүний талаар Улсын Их Хурлын даргатай зөвшилцөх гэж заасны дагуу Улсын Их Хурал дахь МАН-ын бүлэг болон Улсын Их Хурлын гишүүн С.Оюун дэд хорооны бүрэлдэхүүнд орох саналаа, МАХН-МҮАН-ын “Шударга ёс” эвслийн бүлгээс дэд хорооны бүрэлдэхүүнээс Улсын Их Хурлын гишүүн Д.Тэрбишдагвыг чөлөөлүүлэх саналаа тус тус хүргүүлжээ.

Дэд хорооны дарга Улсын Их Хурлын гишүүн Л.Эрдэнэчимэг өнгөрсөн хоёр жилийн хугацаанд агаарын бохирдлыг бууруулах асуудлаар хийсэн ажлаа тайлагнаж, дэд хорооны бүрэлдэхүүнд сайд нар орох нь хурлын ирцэд муугаар нөлөөлж байсныг анхааруулж байлаа.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн С.Дэмбэрэл агаарын бохирдол гэж ярихаас гадна хөрс, усны бохирдлыг ярих зайлшгүй шаардлага бий болоод байгааг анхааруулав. Мөн хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү, Х.Болорчулуун, С.Оюун нар асуулт асууж, саналаа хэллээ.

Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Су.Батболд, Я.Содбаатар, Ч.Хүрэлбаатар, С.Оюун нарыг нэмж оруулахыг, мөн дэд хорооны бүрэлдэхүүнээс Улсын Их Хурлын гишүүн Д.Тэрбишдагвыг чөлөөлөх саналыг гишүүдийн олонх дэмжив.

Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.8-д “Дэд хорооны бүрэлдэхүүнд орсон гишүүн харьяалагдах байнгын хорооны бүрэлдэхүүнээс гарвал тухайн дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлөгдсөнд тооцно” гэснийг үндэслэн Улсын Их Хурлын гишүүн Л.Болд Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хорооны гишүүнээс чөлөөлөгдсөн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гарсан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**БАЙГАЛЬ ОРЧИН,
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



С.БАТБОЛД